



Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

2022

282 байгууллага



1,980.8

сая төгрөг

2023

279 байгууллага



53.6

сая төгрөг

2024

284 байгууллага



89.9

сая төгрөг



ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ЗАРИМ ЗАРДЛЫГ ХЭМНЭЖ, ҮР АШИГТАЙ ЗАРЦУУЛСАН БОЛОВЧ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ШИЛЭН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АЛДАА, ЗӨРЧИЛ БУУРААГҮЙ БАЙНА.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:



Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, албан хаагчдын цалин хөлсийг тухайн шатны ИТХ-аар батлуулаагүй байна.



УТХО, ОНХО-аар хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр явуулсан байна.



Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн ч иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.



Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчин, зураг төсөл бүрэн хийгдээгүй, магадлалын дүгнэлтээр баталгаажаагүй төсөл, арга хэмжээг баталсан нь улсын төсөвт ачаалал нэмэгдэх, хэрэгжилтийн явцад хүндрэл үүсэх эрсдэлийг бий болгосон байна.



Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд Төрийн аудитын газраас жил бүр хяналт хийж ажилласан байна.



Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023, 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар урсгал зардал, хөрөнгийн зардал хэмнэгдсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх оноос өссөн байна.